



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/28

Ховд

Нэмэлт төсвийн данснаас татан төвлөрүүлсэн
мөнгийг буцаан олгох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 43 дүгээр зүйлийн 43.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн төрийн сангийн татан төвлөрүүлэлтийн 100160051499 тоот дансанд 2021 оны жилийн эцэст татан төвлөрүүлсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын 1 205 078 030 төгрөг (Нэг тэрбум хоёр зуун таван сая далан найман мянга гучин)-ийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал, Байгаль орчин аялал жуучлалын сайдын тушаал, Соёлын сайдын тушаалаар эрх шилжсэн хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл болон аймгийн нөөцийн мах, гурил, будаа, элсэн чихэр, өвс тэжээлийн төсвийн үлдэгдлийг 100160051410 тоот дансанд буцаан олгосугай.

2. Дээрх байгууллагаас татан төвлөрүүлсэн 1 205 078 030 төгрөг (Нэг тэрбум хоёр зуун таван сая далан найман мянга гучин)-ийг нэмэлт санхүүжилт татан төвлөрүүлсэн данснаас буцаан олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Давааням) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



2022 01 01 150 D/Zah-A/28-Bd